



МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ДАРГА  
МИЕЭГОМБЫН ЭНХБОЛД ТАНАА

**МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ГИШҮҮН**  
**Лувсангийн ЭНХБОЛД**

14201 Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг,  
Жанжин Д.Сүхбаатарын талбай 1, Төрийн ордон,  
Утас: 26-13-31, Факс: 32-70-16  
E-mail: enkhboldl@parliament.mn  
http://www.parliament.mn

2019.01.18 № 687

танай \_\_\_\_\_-ны № \_\_\_\_\_-т

Хуулийн төсөл өргөн мэдүүлэх  
тухай

Монгол Улсын Үндсэн хуулийн Хорин зургадугаар зүйлийн 1 дэх хэсэг, Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.1.3, Хууль тогтоомжийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан бүрэн эрхийнхээ дагуу Усны тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийг боловсруулан Улсын Их Хуралд өргөн мэдүүлж байна.

Улсын Их Хурлын чуулганы хуралдаанаар хэлэлцүүлж өгнө үү.

Хуулийн төсөл, үзэл баримтлал, танилцуулгыг хавсаргав.

Хүндэтгэсэн,

УЛСЫН ИХ ХУРЛЫН  
ГИШҮҮН

Л.ЭНХБОЛД

А.СҮХБАТ

О.БАТНАСАН

Х.БОЛОРЧУЛУУН

М.ОЮУНЧИМЭГ

Ш.РАДНААСЭД

Б.ЭНХ-АМГАЛАН

Л.МӨНХБААТАР

990039



**МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ГИШҮҮН**  
**Лувсангийн ЭНХБОЛД**

14201 Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг,  
Жанжин Д.Сүхбаатарын талбай 1, Төрийн ордон,  
Утас: 26-13-31, Факс: 32-70-16  
E-mail: enkhbold@parliament.mn  
http://www.parliament.mn

2019.01.18 № 679

танай \_\_\_\_\_-ны № \_\_\_\_\_-т

**Тов тогтоолгох тухай**

Монгол Улсын Үндсэн хуулийн Хорин зургадугаар зүйлийн 1 дэх хэсэг, Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.1.3, Хууль тогтоомжийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан бүрэн эрхийнхээ дагуу Усны тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийг боловсруулсныг хянан үзэж, Улсын Их Хуралд өргөн мэдүүлэх тов тогтоож өгнө үү. (129х).

Хүндэтгэсэн,

УЛСЫН ИХ ХУРЛЫН  
ГИШҮҮН

Л.ЭНХБОЛД

А.СҮХБАТ

О.БАТНАСАН

Х.БОЛОРЧУЛУУН

М.ОЮУНЧИМЭГ

Ш.РАДНААСЭД

Б.ЭНХ-АМГАЛАН

000042



МОНГОЛ УЛС  
ЗАСГИЙН ГАЗРЫН ХЭРЭГ ЭРХЛЭХ ГАЗАР

2018 он 12 дугаар  
сарын 17-ны өдөр

Дугаар ХЯГ/2751

Улаанбаатар-12  
Утас: 260817  
Факс: 976-11-310011


МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН  
ГИШҮҮН Л.ЭНХБОЛД ТАНАА

Хуралдааны тэмдэглэл  
хүргүүлэх тухай

Таны санаачлан боловсруулж Засгийн газрын санал дүгнэлт авахаар ирүүлсэн Усны тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг Засгийн газрын 2018 оны 12 дугаар сарын 12-ны өдрийн хуралдаанаар хэлэлцээд гаргасан тэмдэглэлийг үүгээр хүргүүлж байна.

Хавсралт: 1.. хуудас.

Монгол Улсын сайд,  
Засгийн газрын Хэрэг  
эрхлэх газрын дарга



Г.ЗАНДАНШАТАР

# МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛЭЭС

Монгол Улсын Засгийн газрын 2018 оны 12 дугаар сарын 12-ны өдрийн хуралдааны 51 дүгээр тэмдэглэлд:

“VII.ХЭЛЭЛЦСЭН нь: Улсын Их Хурлын гишүүн Л.Энхболдын санаачлан боловсруулсан Усны тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөлд Засгийн газраас өгөх санал дүгнэлтийн тухай

ШИЙДВЭРЛЭСЭН нь: Улсын Их Хурлын гишүүн Л.Энхболдын санаачлан боловсруулсан Усны тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг хэлэлцээд дараахь үндэслэлээр дэмжих боломжгүй гэсэн саналыг төсөл санаачлагчид уламжлахаар тогтов:


1. Монгол Улсын үндэсний аюулгүй байдлын зөвлөмжийн гуравдугаар зүйлийн 3.5.1.4-т “Газрын доорх цэнгэг усны томоохон ордууд, гол мөрний урсац бүрэлдэх эхийг улсын тусгай хамгаалалтад авах, цэвэр усны нөөц бүхий томоохон нуурын сав газарт аж ахуйн үйл ажиллагааг хязгаарлах замаар усны нөөцийг хамгаална” гэж заасан;

2. Хуулийн төслийн 4 дүгээр зүйлийн 4.3<sup>1</sup>.4 дэх заалтад ус ашиглах эрэмбэлэлд уул уурхай, баяжуулах үйлдвэрийг тусгасан нь төслийн 22 дугаар зүйлийн 22.7<sup>1</sup> дэх хэсэгт “Газрын доорх цэнгэг усны ордыг уул уурхай болон үйлдвэрлэлийн зориулалтаар ашиглахыг хориглоно...” гэж заасантай зөрчилдөж байна;

3. Уул уурхайн салбарын Монгол Улсын нийгэм, эдийн засагт үзүүлэх хувь хэмжээ өсөн нэмэгдэж одоогоор дотоодын нийт бүтээгдэхүүний 22 орчим хувь, экспортын 90 хувь, аж үйлдвэрийн бүтээгдэхүүний 74 хувийг тус тус бүрдүүлж байна;

4. Мөн Улсын Их Хурлын 2014 оны 18 дугаар тогтоолоор “Төрөөс эрдэс баялгийн салбарын талаар баримтлах бодлого” батлагдсан ба уг бодлогын 3.6.4-т “Эрдэс баялгийн олборлох болон боловсруулах үйлдвэрлэлд газрын гүний цэнгэг усыг аль болох ашиглахгүй байх, гадаргын усыг түлхүү ашиглах, холбогдох хуульд заасны дагуу хэрэглэсэн усыг дахин ашиглах, орчин үеийн дэвшилтэт технологийг дэмжих” гэж заасны дагуу уул уурхайн үйлдвэрлэлд гадаргын болон саарал усыг ашиглах, ашигласан усыг алдагдал багатай дахин ашиглах технологийг нэвтрүүлж байна;

5. Хууль тогтоомжийн тухай 21 дүгээр зүйлийн 21.1 дэх хэсэгт заасны дагуу хууль тогтоомжийн хэрэгцээ, шаардлагыг урьдчилан тандан судлах эсхүл тухайн харилцааг зохицуулж байгаа хуулийн хэрэгжилтийн үр дагаварыг үнэлэх, хуулийн төслийн үр нөлөө болон хэрэгжүүлэхтэй холбогдон гарах зардлын тооцоо зэрэг судалгааны тайланг хавсаргаагүй байна” гэжээ.



ЗАСГИЙН ГАЗРЫН ХЭРЭГ ЭРХЛЭХ ГАЗАР